

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА ТАЙЛАН

2022.07.05

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Хяналтад авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 болон 8.1 дэх заалтыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэд байршсан 68 шийдвэрийн 152 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2022 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг хяналтад авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- Монгол Улсын 3 хуулийн 47 заалт;
- УИХ-ын 4 тогтоолын 10 заалт;
- УИХ-ын байнгын хорооны 3 тогтоолын 3 заалт;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 3 заалт;
- Засгийн газрын 32 тогтоолын 47 заалт;
- Засгийн газрын хуралдааны 23 тэмдэглэлийн 41 заалт;
- Засгийн газрын 1 албан даалгаврын 1 заалт нийт **68 шийдвэрийн 152 заалтыг**

хяналтад авч хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн **дундаж үнэлгээ 80.7 хувь** байна.

Гурав. Үнэлгээний дүгнэлт

2021 оны жилийн эцсийн байдлаар 85 шийдвэрийн 121 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийн үр дүнгээр дээд шатны байгууллагаас зөвлөмж, чиглэл өгсний дагуу нэг удаагийн шинжтэй, жил бүр тогтмол гардаг, зохион байгуулалтын арга хэмжээг бүрэн авч хэрэгжилт тогтмолжсон, 49 шийдвэрийн 66 заалтыг дотоод хяналтдаа авч Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан буюу unelgee.gov.mn-ээс хасуулах саналыг 2022 оны 06 дугаар сард цахим санд оруулж баталгаажуулан шийдвэрлүүлсэн байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар шинээр 31 шийдвэрийн 98 заалтыг хяналтдаа авч нийт 68 шийдвэрийн 152 заалтын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар цаг үеийн болон нэг удаагийн шинжтэй, бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон 19 заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэгт хамаарахгүй 11 заалтыг “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” гэж

үнэлэн нийт 30 заалтыг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан буюу unelgee.gov.mn-ээс хасуулах саналыг хүргүүлж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-ХБ 28 заалтын 11 заалт нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэгт хамааралгүй тул цаашид хяналтаас хасуулах, 2 заалт нь заалтын хэрэгжилт гадны хүчин зүйлээс (Төрийн хэмнэлтийн тухай хууль) болж зогссон, 15 заалт 2022 оны жилийн эцсээр хэрэгжилтийг тайлагнаж үр дүнг тооцно.


Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- Хяналтаас хасуулах санал хүргүүлсэн шийдвэрийг холбогдох хэлтсүүд хяналтдаа авах, шаардлагатай тохиолдолд шуурхай горимоор хэрэгжилтийг тайлагнахад анхаарч ажиллах;
- Хэрэгжилтийг тайлагнахдаа үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах, шаардлагатай тохиолдолд файлыг хавсралтаар ирүүлэх;
- Хоёроос дээш жил хяналтад байгаа шийдвэрийг тухайн тайлант оны үр дүнг өмнөх оны гарсан үр дүнгийн хамт харьцуулан тайлагнах;
- Хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр “хэрэгжилт хангалтгүй”-30 хувь, “хэрэгжээгүй”-0 хувьтай шийдвэрүүдийг цаашид анхаарч ажиллах.


Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Н.ГАНБОЛД

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН  Д.ЦЭРЭНЛХАМ

2022.07.05

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)
(2022 оны эхний хагас жилийн дүн)

Улаанбаатар хот

Д/д	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл	Шийдвэрийн тоо	Хэрэгжилтийг тооцсон заалтын тоо	Үүнээс:					Хэрэгжилтийн явцын дүн (хувиар)
				Бүрэн хэрэгжсэн (100%)	Хэрэгжих шатанд (70%)	Хэрэгжилт хангалтгүй (30%)	Хэрэгжээгүй (0%)	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ)	
1	Монгол Улсын хууль	3	47	25	3	-	-	19	96.8%
2	УИХ-ын тогтоол	4	10	4	5	-	-	1	83.3%
3	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	3	3	-	3	-	-	-	70.0%
4	Ерөнхийлөгчийн зарлиг	2	3	2	1	-	-	-	90.0%
5	Засгийн газрын тогтоол	32	47	16	23	4	-	4	77.4%
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	23	41	8	25	3	1	4	71.4%
7	Засгийн газрын албан даалгавар	1	1	1	-	-	-	-	100.0%
Хэрэгжилтийн дүн (шийдвэр, заалтын тоо)		68	152	56	60	7	1	28	80.7%

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА
Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭСНИЙ
ДАРГА
Н.ГАНБОЛД

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН
Д.ЦЭРЭНЛХАМ